

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ....ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16<sup>1</sup> дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 16<sup>1</sup>.3 дахь хэсэг нэмсүгэй.

"16<sup>1</sup>.3.Улсын Их Хурлын гишүүдийн олонхи Улсын Их Хурлын даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьж, тогтоолын төсөл өргөн мэдүүлсэн бол төслийг энэ хуулийн 16<sup>1</sup>.1, 16<sup>1</sup>.2-т заасан журмын дагуу хэлэлцүүлнэ."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 10.2.6 дахь заалт нэмсүгэй.

"10.2.6. Улсын Их Хурлын гишүүдийн олонхи Улсын Их Хурлын даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай саналыг албан ёсоор тавьж, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал хэлэлцэн ёсоор болгосон."

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн "10.2.3-т" гэснийг "10.2.3, 10.2.6-д" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ